

**“АЮУЛГҮЙ АМЬДРАХ УХААН”
СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР**

2017 он

НЭГ. ТАНИЛЦУУЛГА

1.1. Үндэслэл

Болзошгүй аюулаас өөрийгөө хамгаалах, эрсдэлгүй аж төрөх боловсролыг эзэмших нь хүний амьд явах, аюулгүй орчинд амьдрах язгуур эрх ашгаар илэрхийлэгдэнэ.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16.2-т “Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй”¹ гэж тунхагласан.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн чуулганаар баталсан “Тогтвортой хөгжил-2030” хөтөлбөрийн “Тогтвортой хөгжлийн зорилго 4-ийн хүрээн дэх 4.7 дахь зорилгод “2030 он гэхэд бүх суралцагчид тогтвортой хөгжлийн болон тогтвортой амьдралын зан үйл, хэв маяг, хүний эрх, жендерийн тэгш байдал, энх тайванч болон хүчирхийллийн бус соёл, дэлхийн иргэншил болон соёлын олон янз байдал, тогтвортой хөгжилд “соёлын оруулах хувь нэмэр зэрэг тогтвортой хөгжлийг түргэсгэхэд шаардлагатай мэдлэг ур чадварыг эзэмшсэн байх нөхцлийг хангах”² гэж заажээ.

Монгол Улсын “Гамшгаас хамгаалах тухай хууль”-ийн 13.3.6-д “оюутан, сурагч, сургуульд элсэхийн өмнөх насны хүүхдийн сургалтыг батлагдсан сургалтын хөтөлбөрийн дагуу тухайн шатны боловсролын байгууллага зохион байгуулна”³ гэж заасан.

“Бага дунд боловсролын тухай хууль”-ийн 4.1.8-д бага боловсролын агуулгад “зөрчлийг хүчирхийллийн бус аргаар шийдвэрлэх, эрсдэлээс өөрийгөө хамгаалах мэдлэг, харилцааны ур чадвар олгох, 5.1.5-д суурь боловсролын агуулгад “хүчирхийллээс урьдчилан сэргийлэх болон зөрчлийг хүчирхийллийн бус аргаар шийдвэрлэх, эрсдэлээс өөрийгөө хамгаалах мэдлэг, харилцааны ур чадвар олгох”, 6.1.4-т бүрэн дунд боловсролын агуулгад “бие бялдраа хөгжүүлж, эрүүл аж төрөх ёсыг сахих, гэр бүлийн болон амьдрал ахуйгаа хөтлөх, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, өөрийгөө хамгаалах арга барилд сургах, эх оронч, хууль ёсыг дээдлэх үзэл төлөвшүүлэх” гэж 2016 онд нэмэлт өөрчлөлтөөр тус тус оруулжээ.⁴

“Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого”-ын 2.1, 2.2-т заасныг хэрэгжүүлэх зорилгоор баталсан “Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр”-ийн 3.2.10-т “Гамшгийн эрсдэлийг бууруулах, аюулгүй амьдрах ухааны боловсрол, хүмүүжил олгох хичээлийг сургуулийн өмнөх болон бага дунд боловсролын сургалтын хөтөлбөрт оруулах, сургалтыг хүүхдийн насны онцлогт тохируулан явуулах”⁵ гэж, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтын 3.2.14-т “Ерөнхий боловсролын сургуульд сурагчдын амьдрах ур ухааныг хөгжүүлэх, аюулгүй байдлын сургалтыг нэвтрүүлж, хүүхдийг эрсдэлгүй, осол эндэлгүй, эрүүл, аюулгүй амьдрах чадварт сургана”⁶ гэж тус тус заасан.

Уур амьсгалын өөрчлөлт, хүн амын өсөлттэй холбоотойгоор аюулт үзэгдлийн давтамж улам ихсэх төлөвтэй⁷ энэ үед аюулгүй амьдрах, эрсдэлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах чадвартай иргэн болж хөгжих боломжийг бүрдүүлэх зорилгоор аюулгүй амьдрах ухааны сургалтын хөтөлбөрийг санал болгож байна.

¹ Монгол Улсын үндсэн хууль, 1992

² НҮБ, Ерөнхий Ассамблейн баталсан тогтоол 2030 он хүртэлх Тогтвортой Хөгжлийн Хөтөлбөр, 2015

³ Гамшгаас хамгаалах тухай хууль, 2017

⁴ Бага дунд боловсролын тухай хууль, 2002

⁵ Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр, 2015

⁶ Монгол улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, 2016

⁷ Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр, 2011

ХОЁР. ЗОРИЛГО

2.1. Сургуулийн өмнөх боловсрол

Асран хамгаалагчдын дэмжлэгтэйгээр аюул ослын талаар төсөөлөлтэй болох, өөрийгөө хамгаалах аргад суралцаж эхлэх

2.2. Бага боловсрол

Тохиолдож болзошгүй аюул ослыг ойлгох, түүнээс урьдчилан сэргийлэх, өөрийгөө хамгаалах аргад суралцах, хэрэглэх зөв хандлагатай болох

2.3. Суурь боловсрол

Болзошгүй аюулт үзэгдэл, ослын үед бэлтгэлтэй байх, өөрийгөө хамгаалах бусдад туслах, анхны тусламж үзүүлэхэд суралцах

2.4. Бүрэн дунд боловсрол

Болзошгүй аюулт үзэгдэл, ослын үед хариу арга хэмжээ авах, анхны тусламж үзүүлэх, сайн дурын үйл ажиллагаанд оролцох, дасан зохицож амьдрах чадвартай, амьдралын зөв дадал хэвшилтэй, иргэн болж төлөвших

ГУРАВ. АГУУЛГА

3.1. Сургуулийн өмнөх боловсрол

Ахуйн осол

1. Ахуйн ослоос сэргийлэх
 - a. Сургалтын хэрэглэгдэхүүнтэй зөв харьцах /хайч, харандаа, шугам...гэх мэт /
 - b. Нийтээрээ хэлэлцэх бүлгийн болон сургалтын төвүүдийн дүрэм зохиох
 - c. Гадаад талбай, танхимын бус сургалтын үед баримтлах дүрэм боловсруулах
 - d. Үзүүртэй багаж хэрэгслээс болгоомжлох- аяга, таваг, шил, хайч, хутга, сэрээ, савх, харандаа, шугам, барьсан үедээ гүйхгүй байх,
 - e. Зай, жижиг шүр, амны цаас, товчийг чих, хамар, амандаа хийхгүй байх.
 - f. Булан тойрох, шатаар буухдаа бие биеэ түлхэхгүй байх, тэмдэг тэмдэглэгээг таних, мөрдөх.
 - g. Түлэгдэхээс урьдчилан сэргийлэх / халуун тогоо, халуун хоол, цай, ус, гал /
 - h. Болгоомжлох зүйлсийн талаар ярилцах, дасгал сургуулилт хийх
 - i. Унаж бэртэх, гараа эсгэх, шалбалах үед бусдаас тусламж хүсэх, анхны тусламжийн зүйлсээс хэрэглэхийг суралцаж эхлэх
 - j. Гал тогооны өрөөнд юу байгааг нэрлэх, яаж хэрэглэдэг талаар ойлголттой болох, ойртохгүй байх
 - k. Мал амьтнаас өөрийгөө хамгаалах, болгоомжлох / эзэнгүй болон гэрийн тэжээмэл амьтан/ - l. Гэрийн тэжээмэл амьтад болон ургамлыг хайрлах
2. Эм химийн бодистой харьцах
 - a. Насанд хүрэгчдийн тусламжтай эм, ахуйн хэрэглээний химийн бодистой харьцах.
 - b. Эмийг дур мэдэн хэрэглэхгүй байх

Орчны аюулгүй байдал

1. Байгалийн орчин
 - a. Цэцэрлэгийн гадаад дотоод орчинтой танилцах.

- b. Орох, гарах хаалганы шат, довжооноос хальтирахаас сэргийлэх стандарт таних тэмдгийг ялган таних, мөрдөх.
 - c. Хог хаяхгүй байх, хог хаягдлыг зориулалтын саванд хийх.
 - d. Гадаа талбайд тоглох дэгийг мөрдөх
2. Нийгмийн орчин
- a. Зарим нэг замын тэмдэг, тэмдэглэгээг таних, нэрлэх.
 - b. Явган хүний гарц, гэрлэн дохиогоор гарах.
 - c. Зориулалтын бүс зүүх, арын суудалд сууж хөдөлгөөнд оролцох.
 - d. Насанд хүрэгчдийн дэмжлэгтэй зам тээврийн хөдөлгөөнд оролцох.
 - e. Машин зам дээр тоглохгүй байх.
 - f. Автомашины цонхоор толгой, бие, гараа гаргахгүй байх.

Аюулт үзэгдэл, осол

Байгалийн гаралтай аюулт үзэгдэл

1. Галын аюулгүй байдал
 - a. Индүү, халуун тогоо, цахилгаан зуух, сэнсний аюултай талаар ойлголттой болох, ойртохгүй байх, хэрэглэхгүй байх.
 - b. Шүдэнз, лаа, асаагуураар тоглохгүй байх.
 - c. Гал гарсан үед бусдаас тусламж хүсэх, 101,102,103 утасны дугаарыг мэдэх, эцэг эх, ойр дотны хүмүүс рүү залгах
 - d. Цэцэрлэгийн болон гэрийн хаягийг мэдэх, хэлэх
 - e. Гал гарсан үед аль болох хурдан зугтах, гадаа гарах, буцаж орохгүй байх.
2. Газар хөдлөлтийн аюул
 - a. Газар хөдлөлтийн аюулыг мэдэх
 - b. Өөрийгөө хамгаалах(ширээн доогуур орох, толгойгоо хамгаалах, амьтны үйл хөдлөлийг дуурайж суух).
 - c. Насанд хүрэгчдийн зааврын дагуу аюулгүй газарт очих.
3. Үер усны аюул
 - a. Устай зөв харьцах, усыг гамтай хэрэглэх.
 - b. Харгалзах хүнгүй гол, тогтоол усанд орохгүй байх.
 - c. Дуу цахилгаантай аадар бороо орсон үед гэрээсээ гарахгүй байх, гар утас болон цахилгаан хэргслийг унтраах.
4. Хүчтэй салхи, шороон шуурганы аюул
 - a. Цаг агаарын мэдээнээс цас, бороо, салхи шуургыг нэрлэх, ялган таних, тэмдэглэх
 - b. Цаг агаарын нөхцөлд тохируулан зөв хувцаслах

Экологийн гаралтай аюулт үзэгдэл

5. Агаар, ус хөрсний бохирдол
 - a. Хэт нартай үед сүүдрэвчинд тоглох, малгай өмсөх, шингэн зүйл уух, наршихаас сэргийлэх.

Биологийн гаралтай аюулт үзэгдэл

6. Хүн, мал, амьтны халдварт өвчин
 - a. Гадаа тоглож орж ирээд гараа угааж, хоолойгоо зайлж хэвших.
 - b. Бусдын амнаас чихэр, жимс авахгүй байх.
 - c. Мал, амьтны ам хамарт хүрэхгүй байх.
 - d. Халбага, сойз, гар нүүрийн алчуур, хөтөвчийг дамжуулахгүй байх

Нийгмийн гаралтай аюулт үзэгдэл

7. Мэдээлэл, технологийн аюулгүй байдал
 - a. Гар утас, компьютер удаан тоглохгүй байх
 - b. Телевизорийг хязгаартай үзэх.
8. Нийгмийн аюулгүй байдал

- a. Үл таних хүнээс болгоомжлох, дагаж явахгүй байх
- b. Төөрсөн үед бусдаас тусламж хүсэх
- c. Орон зайн, чиглэлтэй холбоотой үг хэллэг хэрэглэн байрлалаа хэлж сурах
- d. Танил орчин, юмсын байршлын хялбар зургийг хараад ярих
- e. Өөрт хамаатай дүрэм мөрдөх

3.2. Бага боловсрол

Ахуйн осол

1. Ахуйн ослоос сэргийлэх
 - a. Эцэг эх, ахмад хүмүүс, найз нөхдийн заавар, зөвлөгөөг сонсох, хэрэгжүүлэх
 - b. Тухайн нөхцөл байдалд найз нөхдийнхөө сэтгэлийн хөдөлгөөн, санаа бодлыг ойлгох, өөрийгөө илэрхийлэх
 - c. Гэрийн хаяг, ойр дотны хүмүүсийн утасны дугаарыг мэдэх
 - d. Хурц ирмэгтэй, үзүүртэй гэх мэт хичээлийн хэрэгсэл болон ахуйн багажийг зориулалт, аюулгүй ажиллагааны зааврын дагуу хэрэглэх
 - e. Эцэг эх, ахмад хүмүүс, найз нөхдийн заавар, зөвлөгөөг сонсох, хэрэгжүүлэх
 - f. Тухайн нөхцөл байдалд найз нөхдийнхөө сэтгэлийн хөдөлгөөн, санаа бодлыг ойлгох, өөрийгөө илэрхийлэх
 - g. Гэрийн хаяг, ойр дотны хүмүүсийн утасны дугаарыг мэдэх
 - h. Хурц ирмэгтэй, үзүүртэй гэх мэт хичээлийн хэрэгсэл болон ахуйн багажийг зориулалт, аюулгүй ажиллагааны зааврын дагуу хэрэглэх
 - i. Ахуйн хэрэглээний зүйлсийн нэр, зориулалт, заавар, шошго уншиж, ойлгох, зориулалтын бусаар хэрэглэхгүй байх
 - j. Эмийг дураар хэрэглэхгүй байх
 - k. Аюултай эд юмсыг ялган таних, бусдад тайлбарлах
 - l. Ахуйн цахилгаан хэрэгслийг эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрлөөр, зааврын дагуу хэрэглэх
 - m. Ахуйн хүрээнд тохиолдох аюул ослыг ялган таних (индүү, плитка, зуух, халуун ус, ууранд түлэгдэхээс сэргийлэх, хурц ирмэгтэй зүйлс, ахуйн хэрэглээний бодисыг зөв хэрэглэх гэх мэт)
 - n. Аюул ослоос сэргийлэх /аюулгүй ажиллагааны заавар дагах, гэмтэж бэртэхээс сэргийлэх г.м./
 - o. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн тохиолдол, ахуйн осол тохиолдсон үед бусдаас тусламж хүсэх
 - p. Цаг агаарын мэдээ ашиглан цаг агаарын өөрчлөлтийг таамаглах, хувцсаа тохируулан өмсөх
 - q. Гар, шүдээ шаардлагатай үед угааж, зөв хооллож хэвших, хүнсний зүйлсийн хэрэглээ
 - r. Орон нутаг дахь шаардлагатай утасны дугаар (101, 102, 103, 107), зориулалтыг мэдэх, хэрэгцээтэй үед зөвийг сонгон аюул ослын талаар болон гэрийн хаяг, байршлыг үнэн зөв мэдээлэх
2. Эм химийн бодистой харьцах
 - a. Ахуйн хэрэглээний зүйлсийн нэр, зориулалт, заавар, шошго уншиж, ойлгох, зориулалтын бусаар хэрэглэхгүй байх
 - b. Эмийг дураар хэрэглэхгүй байх

Орчны аюулгүй байдал

1. Байгалийн орчин
 - b. Улирлын ялгаа, байгаль, нийгмийн юмс үзэгдлийн талаар мэдэх
 - c. Орон нутагт тохиолдож байсан аюул ослын талаарх мэдээлэл, хүснэгт, диаграмм, хялбар графикийг унших, ойлгох, тайлбарлах, судалгаа хийх, аюулгүй байдлыг сахих
 - d. Мал, зэрлэг болон гэрийн тэжээмэл амьтан, ургамалтай болгоомжгүй харьцсанаас ямар аюул учирч болохыг мэдэх (могой, хачиг, халгай, мөөгнөөс сэргийлэх, өндөр модонд авирахгүй байх гэх мэт)

- e. Төөрсөн үед зүг чигээ баримжаалах (од эрхэс, мод, орчин гэх мэт), хаяг, орчны талаарх онцлог зүйлсийг болон дотны хүмүүсийн утасны дугаарыг зөв мэдээлэх
 - f. Дүрэм, журам мөрдөөгүйгээс амьдралын орчинд үүсэх сөрөг үр дагаврыг ойлгох (байгальд, нийгэмд)
 - g. Яаралтай тусламжийн цүнх, үүргэвч, зориулалтыг мэдэх, бэлтгэх, тайлбарлах
3. Нийгмийн орчин
- a. Анги хамт олон, сургуулийн орчны дэгийг мөрдөх
 - b. Сургууль, гэрийн байршлыг мэдэх, бусдад тайлбарлах, багшийн удирдамж, зааврын дагуу сургууль гэрийн орчин, онцлог байгууламж болон сургууль гэрийн хоорондох аюулгүй замын зураглал гаргах, тэмдэглэгээ хийх (план зураг, маршрут, аюултай орчин, байгууламж тусгах гэх мэт)
 - c. Гэр, байрнаас сургууль хүрэх орчин тойрны аюулгүй замыг сонгох, аюулгүй байдлыг ханган явах
 - d. Гэр, сургууль болон олон хүнтэй газар тохиолдож болох аюул, ослыг мэдэх,
 - e. Аюул осол, байршлын талаар бусдад мэдээлэх (101, 102, 103, 108, дотны хүмүүсийн дугаар гэх мэт)
 - f. Өөрийн аюулгүй байдлаа хангах аргыг мэдэх, үйлдэж хэвших
 - g. Замын хөдөлгөөнд оролцох үед явган зорчигчийн үүргийг мэдэх, анхаарал болгоомжтой оролцох
 - h. Замын тэмдэг, тэмдэглэгээг ялган таних, бусдад тайлбарлах
 - i. Тээврийн хэрэгслээр зорчих үед биеэ зөв авч явах (цонхоор хог хаяхгүй, хүнс идэхгүй, гар толгой гаргахгүй, бариулаас барих гэх мэт)

Аюулт үзэгдэл, осол

Байгалийн гаралтай аюулт үзэгдэл

1. Галын аюулгүй байдал
 - a. Гал түймрийн тухай ойлголт, гал түймэр гарах эх үүсвэр, шалтгааныг мэдэх (-лаа, чүдэнз, асаагуур, зөв харьцах -пийшин, зуухны аюулгүй байдал, -цахилгаан хэрэгсэлтэй зөв харьцах, гэх мэт)
 - b. Шаардлагатай тохиолдолд гэр ахуйн цахилгаан хэрэгслийг насанд хүрэгчдийн зөвшөөрөл, зааврын дагуу аюулгүй ашиглах
 - c. Ахуйн шатамхай, тэсрэмтгий бодис (үнэртэй ус, агааржуулагч, цэвэрлэгээний шингэн, будаг, савласан хий гэх мэт) бүхий эд зүйл гэж юу болохыг мэдэх, хялбар шатдаг тэсэрдэг шинжийг ямар тэмдэг, тэмдэглэгээгээр илэрхийлдэгийг ялган тайлбарлах, шаардлагатай тохиолдолд насанд хүрэгчдийн зөвшөөрөл, зааврын дагуу үнэртэн, цэвэрлэх, ариутгах шингэнийг болгоомжтой хэрэглэх
 - d. Сургууль, байгууламж дахь гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл, тэмдэг, тэмдэглэгээ, аврах гарцын зураглал ойлгох, ялган таних, тайлбарлах, хэрэглэж сурах
 - e. Галын аюулаас урьдчилан сэргийлэх, гал түймрийн үед орон байрнаас аюулгүй гарах аргад суралцах, дүрэм журмыг сахих, бага хэмжээний утаа гарч буй эх үүсвэрийг шалгах, насанд хүрсэн хүнд буюу 101 дугаарт үнэн зөв мэдээлэх
 - f. Гамшгийн үеийн зарлан мэдээллийн дохио, галын дохиоллыг ялгах, галын дохиолол ажилласан үед багш, насанд хүрэгчдийн зааврыг дагах, өөрийгөө хамгаалах
2. Газар хөдлөлтийн аюул
 - a. Газар хөдлөлтийг төсөөлөх, авах арга хэмжээний тухай бодох (унаж, нурж, гулсаж ирэхгүй газар хорогдох, ширээн доогуур орох, зарлан мэдээллийг сонсох, багшийн зааврыг дагах гэх мэт)
 - b. Газар хөдлөлт анги танхимаас гадуур /коридор, шатан дээр, бие засах газарт, биеийн тамирын талбай, номын санд гэх мэт / байх үед авах арга хэмжээний талаар эргэцүүлэн хэлэлцэх

- c. Гэртээ байгаа эд зүйлс, тэдгээрийн байршил, гэрийн аюултай, аюулгүй газар (даацын хана гэх мэт), аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар эцэг эхтэйгээ ярилцах
 - d. Эцэг эхтэйгээ гэрийн ойролцоох газруудыг судлах (нурах, гал түймэр гарах, дэлбэрэх, бусад аюултай газрууд, хорогдох байр, цугларах талбай, уулзах газар, явах замын талаар ярилцах, төлөвлөх)
 - e. Газар хөдлөлтийн үед баримтлах дэг журмыг мэдэх (10 алхам: төлөвлөх, аюулаа тодорхойлох гэх мэт)
 - f. Гамшгийн үеийн зарлан мэдээллийн дохиог ялган таних, дохио дуугарсан үед насанд хүрэгчдийн заавар, дүрмийн дагуу ажиллах
3. Үер усны аюул
- a. Аадар бороо, мөндөр, аянга цахилгаанаас урьдчилан сэргийлэх
 - b. Урьд болж байсан үерийн тухай мэдээллийг судлах, түүний тухай санал бодлоо илэрхийлэх
 - c. Үерийн аюул үүсэх шалтгаан, үр дагаврын тухай төсөөлөн ярилцах, туршилт хийх (элсэн дээр)
 - d. Гэр, сургууль, орчин дахь аюулгүй газар, байршлыг судлах
 - e. Үерийн аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар бодох, хэлэлцэх (өндөрлөг газарт гарах, ...)
 - f. Жилийн аль ч улиралд тогтоол ус, гол, нуур, үерийн улмаас тохиолдож болох аюулын тухай мэдэж, урьдчилан сэргийлэх, ослоос өөрийгөө хамгаалах
 - g. Бие бялдараа чийрэгжүүлэх, усны ослоос өөрийгөө хамгаалах зорилгоор багш, насанд хүрэгчдийн удирдлага дор зориулалтын газарт аюулгүй байдлыг бүрэн хангасны үндсэн дээр усанд сэлж сурах
 - h. Үерт өртсөн зүйлсийг хэрэглэхгүй байх, халдварт өвчнөөс сэргийлэх
4. Хүчтэй салхи, шороон шуурганы аюул
- a. Аль улиралд болохыг мэдэх, цаг агаарын мэдээг сонсон үйл ажиллагаагаа зохицуулах, тохируулан хувцаслах, гадагш гарахгүй байх
 - b. Өөрийгөө хамгаалах аргад суралцах (уламжлалт болон орчин үеийн арга)

Экологийн гаралтай аюулт үзэгдэл

5. Уур амьсгалын өөрчлөлт, дасан зохицох
- a. Улирлын ялгаа, ган, зуд, уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдээлэл, хүснэгт, диаграммыг уншиж ойлгох, дүгнэх, ярилцах
 - b. Цаг агаарын хэт халуун болон цочир хүйтрэлийн үед тохиолдож болох аюулууд, тэдгээрээс сэргийлэх, өөрийгөө хамгаалах, аюулгүй байдлаа хангахад анхаарч хэвших
 - c. Цахилгаан хэмнэх, гэрлээ унтраах, усаа хэмнэх, цаасаа гамтай хэрэглэх зэрэгт хэвших, мод тарихын ач холбогдлыг мэдэх, арчлах, хамгаалах

Биологийн гаралтай аюулт үзэгдэл

6. Мал, амьтны халдварт өвчин
- a. Түгээмэл тохиолдох халдварт өвчний тухай ойлголттой болох (ханиад, гэдэсний халдварт өвчин гэх мэт), хамгаалах энгийн аргад сурах, эрүүл ахуйн дэглэм сахих (гар угаах, хоолойгоо зайлах гэх мэт)
 - b. Мөлхөгч, хазагч, хатгагч, шимэгч амьтдаас биеэ хамгаалах (могой, хачиг гэх мэт)
 - c. Хог хаяхгүй байх, бохирдуулахгүй байх

Нийгмийн гаралтай аюулт үзэгдэл

7. Мэдээлэл, технологийн аюулгүй байдал
- a. Мэдээллийн технологийн хэрэглээ, үр бүтээлтэй ашиглахын чухлыг ойлгох, эргэцүүлэн бодох

- b. Мэдээллийн технологийн сөрөг нөлөөлөл, соёлтой хэрэглээний талаар эргэцүүлэх, эрсдэлээс сэргийлэх, нөлөөлөлд автахгүй байх, өөрийгөө хамгаалах
- 8. Нийгмийн аюулгүй байдал
 - a. Гэмт халдлага, хүчирхийлэлтэй холбогдох тохиолдлын талаарх мэдээллийг судлах, хэлэлцэх
 - b. Хүчирхийлэл гардаг газар, орчныг тодорхойлж зайлсхийх
 - c. Үл таних хүн, бусдын нөлөөнд автахгүй байх (үе тэнгийнхний болон бусад хүмүүсийн дарамт шахалт гэх мэт), татгалзаж сурах
 - d. Болзошгүй халдлага, хүчирхийллээс сэргийлэх
 - e. Хүчирхийллийн бус аргаар асуудлыг шийдэж сурах

3.3. Суурь боловсрол

Ахуйн осол

1. Ахуйн ослоос сэргийлэх
 - a. Төөрсөн үед зүг чиг тодорхойлох, аюул ослын дохио өгөх аргуудыг мэдэх
 - b. Аюул ослын үеийн дохиолол, тэмдэг тэмдэглэгээг таних
2. Эм химийн бодистой харьцах
 - a. Эмийг “ЭМЧИЙН” заавраар хэрэглэх
 - b. Хүчиллэг шинжтэй бодис, материалын байгаль орчинд үзүүлэх нөлөөг тодорхойлох
 - c. Цацраг идэвхт бодисын хэрэглээг анагаах ухаан, үйлдвэрлэл дэх жишээгээр тайлбарлах
 - d. Хүний эрүүл мэнд, барилга байгууламжид химийн бодисын үзүүлэх нөлөөг тайлбарлах
 - e. Нүүрсхүчлийн хий, метаныг хүлэмжийн хий гэж нэрлэдэг, хүлэмжийн хийн цаг агаарын өөрчлөлтөд хэрхэн нөлөөлөхийг тайлбарлах
 - f. Нүүрстөрөгчийн моноксид, хүхрийн диоксид, азотын оксидууд болон хартугалганы нэгдлүүд зэрэг агаарын бохирдуулагчдын талаар тайлбарлах
3. Анхны тусламж үзүүлэх
 - a. Гарын доорх материал, багаж хэрэгсэл ашиглан анхны тусламж үзүүлж чаддаг байх (зүрх зогсох, цус алдах, яс хугарах, хөлдөлт, осголт, түлэгдэлт дарагдсан хам шинж болон усанд живсэн хүнд)

Орчны аюулгүй байдал

1. Байгалийн орчин
 - a. Байгаль орчны тэнцвэртэй байдлыг хангах, гамшгийн сөрөг нөлөөг бууруулахад хүний үйл ажиллагаа гол үүрэгтэй гэдгийг ойлгох
2. Нийгмийн орчин
 - a. Үл ойлголцол, маргаан, зөрчлийг шийдвэрлэх, стресс бухимдлаас ангид байх
 - b. Хотжилтын байгаль орчин үзүүлж буй сөрөг нөлөөг мэдэх
 - c. Замын хөдөлгөөний дүрмийг мөрдөх, тэмдэг (дараалал тогтоох, мэдээлэх, хориглох, заах, анхааруулах), тэмдэглэгээг ялган таних, бусдад тайлбарлах

Аюулт үзэгдэл, осол

Байгалийн гаралтай аюулт үзэгдэл

1. Галын аюулгүй байдал
 - a. Гал түймрийн ангилал, объектийн болон ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, бэлэн байдлыг хангах
 - b. Гал унтаагуурын төрөл, зориулалтыг мэдэж, шаардлагатай тохиолдолд хэрэглэх
2. Зарлан мэдээллийн дохио, нүүлгэн шилжүүлэлт
 - a. Эрэн хайх аврах үйл ажиллагааг хэрхэн гүйцэтгэхийг ойлгох

3. Газар хөдлөлтийн аюул
 - a. Газар хөдлөлтийн гамшгийн үеийн бэлэн байдлыг хангах аргыг мэдэх, өөрийн болон бусдын амь насыг аврах
 - b. Өрхийн эрсдэлийн үнэлгээнд суурилсан бэлэн байдлын төлөвлөгөө хийх, турших
4. Үер усны аюул
 - a. Аянга цахилгаанаас өөрийгөө хамгаалж сурах
 - b. Үерийн аюул үүсэх шалтгаан, ангиллыг мэдэх, хамгаалах аргад суралцах
 - c. Орон нутгийн үерийн эрсдэлийн зураг үйлдэх
5. Хүчтэй салхи, шороон шуурганы аюул
 - a. Хүчтэй салхи, цасан болон шороон шуурга үүсэх шалтгааныг мэдэх, аюулаас сэргийлэх орчин үеийн болон уламжлалт аргыг эзэмших

Экологийн гаралтай аюулт үзэгдэл

6. Агаар, ус хөрсний бохирдол
 - a. Хүний үйл ажиллагаа хүрээлэн буй орчин (ус, агаар, хөрс)-д үзүүлж буй нөлөөллийг тайлбарлах, сэргийлэх арга замыг тодорхойлох
7. Ган, зуд, цөлжилт
8. Ган, зудын сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах арга хэмжээг мэдэх
9. Уур амьсгалын өөрчлөлт, дасан зохицох
 - a. Уур амьсгалын нөөц, дэлхийн дулаарал ба хүлэмжийн хийн хамаарлыг тайлбарлах
 - b. УАӨ-ийн эх үүсвэр, шалтгаан, үр дагавар, бууруулах арга замыг тодорхойлох
 - c. Мөнх цас, мөсөн гол, олон жилийн цэвдгийн тархалт байршил ба уур амьсгалын хоорондын хамаарлыг судлах
 - d. Цаг агаарын төлөв байдлыг ажиглах, хэмжих

Биологийн гаралтай аюулт үзэгдэл

10. Мал, амьтны халдварт өвчин
 - a. Хүн, мал, амьтны гоц халдварт өвчнөөс сэргийлэх (сэжигтэй тохиолдолд ойртохгүй байх, мэргэжлийн байгууллагад хандах, мал амьтны гаралтай түүхий эд, хүнсийг боловсруулж хэрэглэх)

Нийгмийн гаралтай аюулт үзэгдэл

11. Мэдээлэл, технологийн аюулгүй байдал
 - a. Цахим орчинд зөв, соёлтой ажиллах
 - b. Оюуны өмч, зохиогчийн эрхийг хүндэтгэх
12. Нийгмийн аюулгүй байдал
 - a. Орон нутгийн засаг захиргаанаас явуулж буй архивалтыг бууруулах, нийгмийн үр дагаврыг багасгах талаар хийж буй арга хэмжээг анхаарч ойлгодог болох
 - b. Героины үйлчлэл хүнийг хүчтэй гутрал, хамааралт байдалд оруулснаар хүний зан ааш эвдэрч, эрс өөрчлөгдөн хулгай хийх, эм тариа хэрэглэх, ХДХВ ба ДОХ-оор өвчлөхөд хүрдэг тухай хэлэлцэх
 - c. Нийтийг хамарсан эмх замбараагүй байдал гэж юу болохыг мэдэх ямар тохиолдолд үүсч болохыг мэдэх

3.4. Бүрэн дунд боловсрол

Ахуйн осол

1. Эм химийн бодистой харьцах
 - a. Аммиак, нүүрстөрөгч, оксид, хлор, устөрөгч, хүчилтөрөгч зэрэг түгээмэл хэрэглэгддэг хийг таних

- b. Хүчиллэг хөрсийг боловсруулах, үйлдвэрлэлийн хүчиллэг хаягдлыг саармагжуулах зэрэг түүхий эд болон болсон шохойн хэрэглээг нэрлэх
 - c. Хүхрийн хэрэглээг нэрлэх
2. Анхны тусламж үзүүлэх
- a. Химийн бодисын хордолт, цахилгаан гүйдэлд цохиулах үед анхны тусламж үзүүлэх аргад суралцах, өөрийгөө хамгаалах аргад суралцах

Орчны аюулгүй байдал

1. Байгалийн орчин
- a. Газрын доройтлоос болон хөрсийг хамгаалах аргыг практикт хэрэглэх
 - b. Далай, тэнгисийн бохирдол, түүний үр дагаврыг дүгнэх
 - c. Хөрсний доройтол, геологийн, цаг уурын , усан мандлын гаралтай аюулт үзэгдлийн нийгэм, эдийн засагт үзүүлэх хохирол, сэргийлэх арга замыг тодорхойлох
 - d. Хөрсний доройтлын өнөөгийн байдал, шалтгааныг бүс нутгийн жишээгээр харьцуулах
2. Нийгмийн орчин
- a. Хүн амын суурьшил, нягтшилд байгалийн нөхцөл нөөц нөлөөлдөг болохыг ойлгох
 - b. Хүн амын нягтшил ихтэй бүс нутгуудын байгаль нийгэм газарзүйн орчныг тайлбарлах, дүгнэлт гаргах
 - c. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, дүрмийг мөрдөх, аюулаас урьдчилан сэргийлэхийн ач холбогдлыг ойлгох (цусны бүлэг тодорхойлохын ач тус)

Аюулт үзэгдэл, осол

Байгалийн гаралтай аюулт үзэгдэл

1. Галын аюулгүй байдал
- a. Гал гарсан үед ажиллах төлөвлөгөө гаргах, түүний дагуу дадлага сургуулилалт хийх
 - Урьдчилан сэргийлэх
 - Гамшгийн үед ажиллах (анхны тусламж үзүүлэх)
 - Хойшлуулшгүй сэргээн босгох
2. Газар хөдлөлтийн аюул
- a. Газар хөдлөлтөөс үүсэх эрсдэлийг тодорхойлох, түүнээс сэргийлэх, шийдвэр гаргах арга барилд суралцах
3. Үер, усны аюул
- a. Усанд сэлж сурах, гол усны ослоос өөрийгөө болон бусдыг хамгаалах
 - b. Усан мандлын гаралтай байгалийн гамшиг, үүсэх шалтгаан үр дагаврыг тайлбарлах
 - c. Өөрийн орон нутагт байдаг гол мөрөн, нуурын өөрчлөлтөд нөлөөлж буй хүчин зүйлсийг илрүүлэх, усны хомсдолоос сэргийлэх арга замыг тодорхойлох
 - d. Усны хямрал үүсэх шалгаан, үр дагавар, хил дамнасан усны асуудлыг Нил, Меконг мөрний сав газрын жишээн дээр судлах
4. Хүчтэй салхи, шороон шуурганы аюул
- a. Уур амьсгалын гаралтай байгалийн гамшгийн үргэлжлэх хугацаа, үүсэх шалтгаан үр дагаврыг дүгнэх (угалз, цасан болон шороон шуурга, циклон, гэнэтийн хүйтрэл)

Экологийн гаралтай аюулт үзэгдэл

5. Ган, зуд, цөлжилт
- a. Ойгүйжилт түүнд нөлөөлж буй хүчин зүйл үүсэх үр дагавар, хамгаалах арга замыг тодорхойлох

- b. Дэлхийн хүн амын хүнс тэжээлийн хүрэлцээ, хангамж, ган гачиг хүн амд нөлөөлөх талаар хэлэлцэх
- 6. Уур амьсгалын өөрчлөлт, дасан зохицох
 - a. Уур амьсгалын өөрчлөлтийн үр дагавар, ган зудын давтамжид нөлөөлөх талаар хэлэлцэх
 - b. Уур амьсгалын өөрчлөлтийн шалтгаан, үр дагавар, дасан зохицох арга замыг тайлбарлах

Биологийн гаралтай аюулт үзэгдэл

- 7. Мал, амьтны халдварт өвчин
 - a. Хортон мэрэгч, шавьж тархах үеийн арга хэмжээ, байгаль орчинд нөлөөлөх талаар хэлэлцэх
- 8. Хорио цээр
 - a. Хүн, мал, амьтны гоц халдварт өвчний хорио цээрийн дэглэмийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээнд суралцах

Нийгмийн гаралтай аюулт үзэгдэл

- 9. Мэдээлэл, технологийн аюулгүй байдал
 - a. Нийгмийн сүлжээг аюулгүй, зохистой ашиглах, тохиргоо хийх аргыг мэдэх
 - b. Хувийн мэдээллээ дэлгэхгүй байх, интернетэд зөвшөөрөлгүй мэдээлэл, зураг тараах талаарх сөрөг нөлөөг ойлгох
- 10. Нийгмийн аюулгүй байдал
 - a. Террорист халдлага, хүчирхийлэл, бэлгийн мөлжлөг, хүний наймаа, эдгээрээс сэргийлэх, хамгаалах арга зам
 - b. Нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын үед биеэ хэрхэн зөв авч явах аргыг мэдэх, бусдын аюулгүй байдлыг хангах

ДӨРӨВ. АРГА ЗҮЙ

4.1. Арга зүйн зарчим, үйл ажиллагаа, хөгжүүлэх чадвар

4.1.1. Сурган хүмүүжүүлэх уламжлалыг орчин үеийн сургалтын аргуудтай хослуулан дараах сургалтын зарчмуудыг баримтална. Үүнд:

- Асуудлыг олж харах, шийдвэрлэх арга замыг эрэлхийлэх
- Хичээл болон хичээлээс гадуурх үйл ажиллагаатай уялдуулан хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөх
- Сурагч төвтэй, оролцоонд тулгуурласан байх
- Өгөгдөл, мэдээлэлтэй ажиллах, шийдвэр гаргах гэх мэт сурах үйл ажиллагааг дэмжсэн байх
- Хамтын ажиллагаанд суурилсан байх

4.1.2. Үйл ажиллагаа

Сургалтыг танхимын ба танхимын бус хэлбэрээр хичээл хоорондын интеграцыг ханган зохион байгуулахын зэрэгцээ дараах үйл ажиллагаануудыг хэрэгжүүлж болно.

- Орон нутгийн мэргэжлийн ба төрийн бус байгууллага, сургалтын төвийн үйл ажиллагаатай танилцах
- Мэргэжлийн байгууллага, эцэг эхийн хамтын ажиллагаанд тулгуурлан дадлага, сургуулилалт хийх
- Уулзалт, ярилцлага, хэлэлцүүлэг зохион байгуулах
- Төсөлт ажил, судалгаа хийх
- Аялал экскурс хийх
- Тайлан бичих, хамгаалах
- Бүтээлч санал санаачлага бүхий сайн үйлсийн аян өрнүүлэх

4.1.3. Дээрх зарчмыг баримтлан сурагчийн мэдлэг, чадвар, хандлагыг төлөвшүүлэхдээ 21 дүгээр зуунд суралцагчдын эзэмшвэл зохих чадамж, чадваруудыг хөгжүүлэхэд анхаарах нь чухал. Үүнд:

А/. Шүүмжлэлт болон шинэлэг сэтгэлгээ:

- Бүтээлч чадвар
- Хувиараа бизнес эрхлэх чадвар
- Зохион бүтээх чадвар
- Хэрэглэх чадвар
- Эргэцүүлэх чадвар
- Шийдвэр гаргах чадвар
- Тунгаан бодох ойлгох

Б/. Хүмүүс хоорондын харилцаа:

- Харилцааны чадвар
- Зохион байгуулах чадвар
- Багаар ажиллах чадвар
- Хамтарч ажиллах чадвар
- Нийтэч байх чадвар
- Өөрийгөө бусдын оронд тавьдаг байх, бусдыг өрөвдөх

В/. Хувь хүний:

- Хувийн сахилга бат
- Бие даан суралцах
- Дасан зохицох
- Шаргуу байдал
- Хувийн сэдэл тэмүүлэл, өөрийгөө хүндэтгэх

Г/. Дэлхий нийтийн иргэншил:

- Хүлээцтэй байх
- Нээлттэй байх
- Хариуцлагатай байх
- Ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандах
- Ёсзүйтэй байхыг ойлгох
- Олон талт соёлыг ойлгох
- Зөрчилдөөнийг шийдвэрлэх
- Чөлөөт оролцоотой гоор шийдвэр гаргах
- Хүрээлэн буй орчиндоо хүндэтгэлтэй хандах, үндэсний онцлогоо мэдэх

Д/. Мэдээллийн технологийн хэрэглээ:

- Мэдээлэл харилцааны технологиор дамжуулан мэдээлэл олж авах
- Мэдээлэлд дүн шинжилгээ хийх
- Мэдээллийн технологийг ёс зүйтэй ашиглах

4.2. Орчин, хэрэглэгдэхүүн

4.2.1. Сургалтын орчин

Сургууль, цэцэрлэгийн гадаад, дотоод орчны аюулгүй байдлыг хангасан байна.

Тухайлбал:

- Сургууль, цэцэрлэгийн байр зүйн болон аврах гарцын зураглал гаргасан байна.
- Гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл болох хүрз, хувин, элс, шатдаггүй бүтээлэг, гал унтраагуур, утаанаас хамгаалах зориулалтын алчуур бэлтгэсэн байх
- Анги бүрт эмнэлгийн анхан шатны тусламжийн хэрэгсэл болон гамшиг ослын үеийн бэлэн байдлыг хангах цүнх бэлтгэсэн байх

4.2.2. Хэрэглэгдэхүүнд тавигдах шаардлага

- Эрүүл ахуйн шаардлага хангасан байх
- Ашиглахад энгийн хялбар бүтэц зохиомжтой байх
- Эдийн засгийн хэмнэлттэй байх
- Байгаль орчинд ээлтэй байх
- Мэдээлэл технологийн ололт, амжилтыг хэрэглэх

4.2.3. Нийтлэг хэрэглэгдэхүүн

- Сургалтыг зохион байгуулахдаа орон нутаг, сургууль, цэцэрлэгийн нөөц боломжид тулгуурлан дараах хэрэглэгдэхүүнээс сонгон хэрэглэж болно. Үүнд:
 - Аудио, видео материал
 - Төрөл бүрийн зураг
 - Газрын зураг
 - Ном, гарын авлага
 - Интернет
 - Багаж хэрэгсэл
 - Загвар, модель
 - Танин мэдэхүйн болон судалгааны мэдээлэл, баримт материал

ТАВ. ҮНЭЛГЭЭ

Сурагчдын санал санаачлага, оролцоо, нөлөөлөл, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, дадлага сургуулилалтын үр дүнгээр үнэлнэ.